

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2025-2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 05 дугаар
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хуулийн төсөлд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг бүрэн тусгасан эсэх, хүүхдийн тэтгэмж нь нэгдсэн төсвийн зардалд ачаалал үзүүлж байгаа тул тус зардлыг нэгдсэн төсвийн зардлаас Ирээдүйн өв санд шилжүүлж хүүхдийн хуримтлалтай болох боломжтой эсэх, үр дүнд нь төсвийн тэнцлийг сайжруулах боломжтой эсэх, мөн Засгийн газрын өрийн хэмжээг хуулийн төслийн танилцуулгад дурдсан 49 хувьд барих боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн хүрээний мэдэгдлийг хэлбэрэлтгүй даган 2024 оны төсвийн төслийг боловсруулахдаа энэ удаагийн төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэх боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь "60" гэснийг "51" болгож, мөнгөн дүнг тус тус бууруулах гэсэн зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.


Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Г.ТЭМҮҮЛЭН